



СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.23 №14 (14)

МОНГОЛ ХҮН САНСАРТ НИССЭНИЙ 40 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ҮЗЭСГЭЛЭН НЭЭГДЛЭЭ



бүхэндээ сансрын хамтарсан нислэгийн ойн баярын мэнд хүргэж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Би одоогоос 40 жилийн өмнө сандарч байсан шигээ сандарч байна. Ийм өндөр шагналуудыг зэрэг хүртэнэ гэдэг миний хувьд асар их хүндэтгэл. Монгол, Орос хоёр улсын ард түмний зүгээс үзүүлж байгаа гүн хүндэтгэл юм. Энэ бол дан ганц миний шагнал бус надтай хамт мөр зэрэгцэн Монголын сансар судлалыг хөгжүүлсээр ирсэн хамт олны ялангуяа миний нөхөр М.Ганзоригийн минь гавьяа гэдгийг энд тэмдэглэн хэлэхэд таатай байна” гэж хэлсэн.

Түүнчлэн НИТХ-ын дарга Ж.Батбаясгалан Ж.Гүррагчаад “Нийслэл Улаанбаатар хотын Хүндэт иргэн”-ий тэмдгийг гардуулж, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, сансрын нисэгч М.Ганзориг, түүний гэргий Ц.Ломбо, Монгол Улсын Үйлчилгээний гавьяат ажилтан, Монголын сансрын багийн гишүүн С.Сайнцог нарт “Хангарьд” одонг гардууллаа.

Үзэсгэлэнд Монголын ШУА, ОХУ-ын ШУА, Одон орон судлал, геофизикийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Монгол цэргийн музей зэрэг 14 байгууллагын сансар судлалтай холбоотой үзэмрүүд дэлгэгдсэн юм.

Хүн төрөлхтөн сансрын уудамд гарсны 60 жил, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойг тохиолдуулан “Хүн-Эх дэлхий-Сансрын уудам” нэртэй Монгол-Оросын хамтарсан үзэсгэлэн Оросын шинжлэх ухаан, соёлын төвд боллоо.

Нээлтийн ёслолд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ШУА-ийн

ерөнхийлөгч Д.Рэгдэл, БНМАУ, ЗХУ-ын баатар, Чингис хаан одонт, Александр Невскийн одонт, сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаа болон бусад албаны хүмүүс оролцлоо.

Энэ үеэр Шадар сайд С.Амарсайхан хэлсэн үгэндээ “XX зууны Монголын сэргэн мандалтын түүхэнд алтан үсгээр бичигдэх зүйл бол яахын аргагүй малчны гэрт төрсөн хүү одот тэнгэрийн зүг

жолоо залсан явдал байлаа. Ж.Гүррагчаа сансрын уудамд гарч анагаах ухаан, биологийн олон туршилт хийсэн нь Монголын шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан юм. Өнөөдөр түүний үйл хэргийг үргэлжлүүлэн залуу үе маань “Мазаалай” хиймэл дагуулыг бүтээж хөөргөн геофизик, зайнаас тандан судлахад маш их ахиц авчраад байна. УИХ-аас баталсан “Алсын

хараа-2050” хөгжлийн бодлогын хөтөлбөрт сансар судлалыг хөгжүүлэх талаар тодорхой заалтуудыг тусгасан. Өөрөөр хэлбэл, бид 2050 он гэхэд өөрсдийн гэсэн холбоо, мэдээллийн хиймэл дагуултай болж, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоогоо сайжруулахаар зорьж байна” хэмээн дурдсан юм.

Сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаа “Та

ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРАХЫГ ЗАХИЛАА



Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нартай цар тахлын халдварын тархалт өдрөөс өдөрт нэмэгдэж буйтай холбогдуулан хэрхэн урьдчилан сэргийлэх талаар цахим хурал хийлээ.

Энэ үеэр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яамны заавар, зөвлөмжийг ягштал мөрдөж бие бүрэлдэхүүнийхээ тоог аль болох багасгаж ажиллах, ажлын байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх зэрэг сэдвээр заавар зөвлөгөө өгсөн юм. Ялангуяа хугацаат цэргийн алба хаагчдынхаа сургалт бэлтгэлийг

вакумжуулсан орчинд явуулж, байнгын бүрэлдэхүүн хугацаат албаны дайчидтай харилцахгүй байхыг онцгойлон анхааруулав. Мөн нэгтгэл, ангийн байрлал руу нэвтрэх хэн ч гэсэн заавал PCR шинжилгээ өгч, хариугаа авсан байх, вакцин хийлгэсэн алба хаагчдад ч энэ хамаатай гээд нэгтгэл, ангиудын захирагч нарын сонирхсон асуултад хариуллаа. Хурлын төгсгөлд ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтэс болон Цэргийн албаны хэлтсээс цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, хорио дэглэмийн үед алба хаагчдынхаа нийгмийн байдалд анхаарч, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд холбогдох албан тушаалтнуудыг хяналтаа тавьж ажиллахыг үүрэг болгосон юм.

“ЗАПАД-2021” СУРГУУЛЬД 18 УЛС ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЭВ



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Запад-2021” стратегийн команд штабын сургуулийн нэгдүгээр шатны төлөвлөлтийн хурал цахимаар боллоо. Дэлхийн 18 орны Зэвсэгт хүчний төлөөлөл оролцсон энэ сургуулийн төлөвлөлтийн хуралд анх удаа Монгол Улсын Зэвсэгт хүчин оролцохоор байр сууриа илэрхийлж, сургуулийн сэдэв, явагдах газар орон, оролцох бүрэлдэхүүний талаар санал солилцсон юм.

Төлөвлөлтийн хуралд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлж Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр нарын албаны хүмүүс оролцлоо. Энэ жил тус сургууль “Холбоотон улсуудын цэргийн аюулгүй байдлыг хангах сонирхолд цэргийн бүлэглэл (хүч)-ийг хэрэглэх нь” сэдвийн хүрээнд хоёр үе шаттайгаар явагдана. Нэгдүгээр үе

шат нь “Дайны эхний үеийн операцад цэргийн бүлэглэлийг (хүч) удирдах” сэдвийн хүрээнд, хоёрдугаар үе шат нь “Дайсныг бут цохих явцад цэргийн бүлэглэлийг (хүч) удирдах” сэдвийн хүрээнд тус тус явагдах бөгөөд сургуулийг 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна хэмээн ОХУ-ын Зэвсэгт хүчнээс мэдэгдсэн юм. Мөн энэ үеэр 18 орны Зэвсэгт хүчин оролцогч болон ажиглагчаар оролцоно гэдгээ илэрхийллээ.

Дашрамд дурдахад, Монгол Улсын Зэвсэгт хүчний хувьд Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөс зөвшөөрсөн тохиолдолд тус сургуульд оролцох юм.

“Запад” стратегийн команд штабын сургууль нь “Кавказ” сургуулийн үргэлжлэл бөгөөд өмнө нь энэ нэрээрээ зохион байгуулагдаж ирсэн бүс нутгийн томоохон сургууль юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5°C	☁️ -5°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38°C	☁️ 27°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12°C	☁️ 0°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,363.0	3,428.0
CNY 🇨🇳	435.50	439.80
RUB 🇷🇺	37.53	39.26
JPY 🇯🇵	25.90	26.53
KRW 🇰🇷	2.46	2.57

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	210
НИЙТ БҮРТГЭГДСЭН	5186
ЭДГЭРСЭН	3606
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	12
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	251
ЭДГЭРСЭН	1013

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.23
/МЯГМАР ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ДОЛООН УЛААН ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулвал:
Эрч хүч ихэснэ
Наран ургах, шингэх:
06.49-19.09
Барилдлага: Хүчин төгсөх
Шүтэн барилдлага: Өтлөх
үхэхүй
Суудал: Төмөр

Аргын тооллын 3 душаар сарын 23, Ангараг гараг. Билгийн тооллын 10, Өглөлт охин одтой, цагаан морь өдөр. Өдрийн наран 6 цаг 49 минутад мандан, 19 цаг 09 минутад жаргана. Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, гарагийг тахиж, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улай гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогосод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.

ЦЭРЭГ ТАТЛАГЫН БАЙРЫГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛЛАА

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас "Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан цөөнгүй ажил, арга хэмжээг хэрэгжүүлсний нэг нь нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн засвар,

тохижилтын ажил байв. Учир нь тус дунд сургуулийн байрыг хавар, намрын улиралд цэрэг татлагын байраар ашиглаж байгаатай холбогдуулан спорт заал, коридор болон зарим анги, танхимыг засварлаж, цэрэг-эх орны сэдэвт зурагт үзүүлэнгээр тохижуулсан юм.

Энэ үеэр 5 дугаар дунд сургуулийн захирал Н.Гэндэнсүрэн "Үнэхээр их баярлалаа. Манай сурагчид цэрэг дайчдад элэгтэй хүүхдүүд. Олонх нь хугацаат цэргийн алба хаана гэдэг. Энэ нь Цэргийн штабаас хүүхэд багачуудад хандсан цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх ажлыг байнга хийж байгаатай холбоотой" хэмээн талархал илэрхийллээ.

Мөн Батлан хамгаалах яам, "Отгон тэнгэр" их сургууль хамтран зохион байгуулсан "Эрхмийн дээд Монгол эр хүн" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд гуравдугаар байр эзэлсэн ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 12в ангийн сурагч Б.Ариунтуяад талархал, өргөмжлөлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, цэрэг татлагын товчооны дарга П.Баянбаатар гардуулан өгч, амжилт хүссэн юм.

СЭТГЭЛ ЗҮЙН МЭРГЭШҮҮЛЭХ ДАМЖААНД МОНГОЛ ОФИЦЕРУУД АМЖИЛТТАЙ СУРАЛЦАВ



Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн соёл хүмүүжлийн офицер, ахмад П.Түвшинтөгс, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн сөрөг тусгай ажиллагааны ротын салааны захирагч, бүлгийн дарга, ахлах дэслэгч М.Мөнхбаатар нар АНУ-ын Хойд Каролина муж дахь Тусгай

хүчний харьяа "Жон Ф. Кеннедийн нэрэмжит Тусгай байлдааны ажиллагааны сургалтын нэгдсэн төв"-ийн "Psychological Operation Qualification Course" буюу "Сэтгэл зүйн ажиллагааны мэргэшүүлэх дамжаа"-нд 2021 оны 1 дүгээр сарын 10-наас 3 дугаар сарын 19-ний өдрийг

хүртэл суралцаж амжилттай төгслөө. Сургалтад 120 гаруй офицер, ахлагч хамрагдсанаас АНУ-ын 29 офицер, 40 ахлагч, Монгол Улсаас 2 офицер, Египетээс 1, Италиас 1, Өмнөд Солонгосоос 1, Пакистанаас 2 офицер тус тус суралцаж төгсжээ.

Сургалтын явцад АНУ-ын Тусгай ажиллагааны командлалын дарга, генерал Ричард Д. Кларк сэтгэл зүйн ажиллагааны мэргэшүүлэх дамжааны суралцагчдын явц байдалтай танилцаж, түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчнээс уг мэргэжлээр анхлан суралцаж буй офицеруудын санал сэтгэгдлийг сонсож, үнэтэй зөвлөгөөг өгсөн байна. Түүнчлэн хээрийн сургалт бэлтгэлийн явцад АНУ-ын армийн Ази номхон далайн командлалын дарга, хошууч генерал Jonathan P. Braga олон улсын суралцагч нараас Монгол Улсыг онцолж, ахмад П.Түвшинтөгстэй уулзан сэтгэл зүйн ажиллагааны мэргэшүүлэх дамжааны талаар санал сэтгэгдлийг нь сонсжээ.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ГАРЫН БЭЛЭГ ӨГЛӨӨ

Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиудад алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдад эргэлээ.

Арга хэмжээний хүрээнд цэргүүдэд Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Засаг даргын мэндчилгээг хүргэснээс гадна коронавируст халдварын тахлаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2000 ширхэг амны хаалт, 800 ширхэг амин дэм, 200 ширхэг гар ариутгагч



болон ариутгалын хэрэгслийг Цэргийн штабын дарга, хурандаа Г.Жаргалсайхан ангийн удирдлагад гардуулан өглөө.

ГАРНИЗОНЫ БАЙЛДАГЧ Ж.БАЯНМӨНХ ДЭД БАЙРТ ШАЛГАРАВ

Зэвсэгт хүчний 336 дугаар анги



Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран явуулсан "Цэрэг эрсийн дуулал" цэрэг-эх орны сэдэвт дууны уралдаан амжилттай явагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд Хилийн цэргийн 0168 ангийн ахлах ахлагч М.Болормаа, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байлдагч Ж.Баянмөнх, Сайншанд сумын иргэн М.Эрдэнэгомбо нар эхний 3 байрыг эзэллээ.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ЦАХИМ ШУУДАНД

"ЦЭРЭГ-ЭХ ОРОН" СЭДЭВТ ЦАХИМ ДУУНЫ УРАЛДААН БОЛОВ

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 090 дүгээр тусгай рот



Монгол Улсад Батлан хамгаалах яам үүсэн байгуулагдсаны 110 жил, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан "Цэрэг-Эх орон" сэдэвт цахим дууны уралдааныг зохион байгууллаа. Тэмцээн 2 үе шаттай явагдсан

бөгөөд 1 дүгээр шатанд бичлэг хэлбэрээр хүлээн авч, Зэвсэгт хүчний 090 дүгээр тусгай рот гэсэн хаягт байршуулан хамгийн их дэмжигдсэн "LIKE, SHARE"-ын тоогоор шалгаруулав. Эхний шатанд Хатанбулаг сумын харьяат 10 ардын авьяастан оролцсоноос 2 дугаар шатанд 4 нь тунаж Хатанбулаг сумын Ахмадын хорооноос оролцогч МУСТА, ая зохиогч Ш.Тэрбиш, МУСТА Ц.Цэцэг, Д.Азбаяр нар эхний 3 байрыг эзэлж, Хилийн цэргийн 0168 дугаар ангиас оролцсон Б.Тэмүүжин шагналт байрт шалгарлаа.

АХМАД ДАЙЧДАДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 086 дугаар тусгай рот

"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан тус ротод ажиллаж байгаад чөлөөндөө гарсан ахмад дайчдад хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Хүндэтгэлийн арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас зарим ахмад дайчныг шагнаж урамшууллаа.



БҮТЭЭЛЧ АЖЛААР ОЙГОО УГТАВ

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 278 дугаар байгууламж



Батлан хамгаалах яамны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жил, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан "Бүтээлч ажлаар ойгоо угтъя" аяныг зохион байгуулав. Аяны хүрээнд тус байгууламжийн автотехникийн офицер, дэслэгч Б.Данзандоржоор ахлуулсан 7 цэргийн алба хаагч тавиулангийн хаалгануудыг завсарлах, шинээр будаж өнгийг сэргээх, дотор ханыг завсарлан,

шохойдох, хагарсан цонхнуудыг шинээр сольж, хүрээндүүдийг будаж өнгө үзэмж сайжруулах зэрэг ажлыг хийж, ая тухтай ажиллах нөхцөл байдлыг бүрдүүллээ. Тавиулангийн засвар үйлчилгээ, тохижилтыг хийхэд зарцуулагдсан нэг сая хоёр зуун мянган төгрөгийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бүрдүүлсэн бөгөөд түүхт ойгоо ийнхүү бүтээлч ажлаар угтсан юм.

ЦАХИМ СУРГАЛТ ЯВУУЛАВ

Зэвсэгт хүчний 124 дүгээр анги



Биеийн тамирын офицер, хошууч Б.Хэнзээ, ангийн эмч, ахлах дэслэгч Г.Сүлгэгмаа нар Ахлагчийн зөвлөлтэй хамтран "Гамшиг, осол гэмтэл, Covid-19

цар тахал, бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл чийрэг хөдөлгөөн" сэдвээр ахлагч нарт цахим сургалтыг зохион байгууллаа.



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАЛАМБА,
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сониний редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сониний мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029